



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/330

Булган сум

Г Нэгдсэн арга хэмжээ болон “Эрүүл Булган”
хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.4, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос, хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор нэгдсэн арга хэмжээг “Эрүүл Булган” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулсугай.

2.Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Б.Чулуунчимэг (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Шижирбаатар (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)

Б.Бүрэндондов (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч)

С.Ерөө (Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч)

Д.Гүндэгмаа (Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн эмч)

Ц.Азжаргал (Нэгдсэн эмнэлгийн эх барих,
эмэгтэйчүүдийн эмч)
Г.Баярмаа (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмч)
Г.Цэрэнлхам (Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн эмч)
Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого
хариуцсан ахлах мэргэжилтэн)

3. Нэгдсэн арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, "Эрүүл Булган" хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээний хөтөлбөрийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Арга хэмжээг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

5. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 3,546,803 (гурван сая таван зуун дөчин зургаан мянга найман зуун гурав) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.



Аймгийн Засаг даргын 2025. оны

05 дугаар сарын 15-ны/ний өдрийн
A/330 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦОГЦООР
ХҮРГЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

ҮНДЭСЛЭЛ: 2024 оны жилийн эцсийн байдлаар 15157 өрхийн 60130 иргэд бүртгэгдсэн бөгөөд 74.5 хувь хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байна. Хүн амын дийлэнх нь хөдөө тархан суурьшиж байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг түргэн шуурхай авах, аймгийн төв рүү явах шаардлагатай болох, мэдээлэл авахад хүндрэлтэй байх бэрхшээл байсаар байна.

Цаашид иргэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, эрүүл мэндийн даатгалд хамрагдах, нийгмийн халамж, соёл, урлагийн үйлчилгээг сумандаа авах хэрэгцээ, шаардлага байна. Иймд нийгмийн салбарын байгууллагуудын уялдааг сайжруулан, хамтран иргэдэд чанартай үйлчилгээг үзүүлэх юм.

ЗОРИЛГО: Хөдөөгийн хүн амд нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, эрүүл мэндийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт...гм)-г нэг дорос хурдан, шуурхай хүргэх замаар нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих зорилготой.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг тус арга хэмжээг удирдан чиглүүлж, нийгмийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: Нийгмийн үйлчилгээг 0-17 насны хүүхэд, 18-34 насны залуучууд, төрийн албан хаагчид, зорилтот өрхийн гишүүд, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэд, зорилтот өрхийн гишүүд

Баяннуур суманд-2025 оны 05 дугаар сарын 19-21 өдөр
Дашинчилэн суманд-2025 оны 05 дугаар сарын 21-22 өдөр

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:

- Шүд, амны хөндийн эрүүл мэндийн үзлэг болон шүд цоорох өвчний эмчилгээнд 2-17 насны хүүхдүүдийг хамруулна.
- 18-34 насны залуучуудыг шүд, элэг, бөөр, дотоод шүүрлийн эрхтний үзлэг, оношилгоонд хамруулах
- Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг бөөр, хөх, умайн хүзүүний өмөн, БЗДХ/ХДХВ, элэгний В, С вирус, хеликобактери зэрэг өвчин, эмгэгийг илрүүлэх үзлэг, үнүүшилгүүнд хамруулах
- Ахмад настан болон эрэгтэйчүүдийг элэг, бөөр, дотоод шүүрлийн эрхтний үзлэг, оношилгоонд хамруулах
- 2-17 насны хүүхдүүдэд шүд цоорох өвчнөөс сэргийлэх, шүдээ зөв угаах 24/3 сургалтыг зохион байгуулах

- Өсвөр насын сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулах
- Насанд хүрэгчдэд халдварт бус өвчинеөс урьдчилан сэргийлэх, сурьеэ өвчний талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах

2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ:

- Залуучууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, ажилгүй иргэдэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулах

3. Халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ:

- Амьжирааг дэмжих зорилтот 20 өрхөөр ажиллаж, сумандаа хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөлийг судалж, сумын удирдлагатай хамтран сум орон нутгаас хамааралтай шийдэж болох асуудлыг шийдвэрлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоон мэдээлэл, судалгаатай танилцах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон асран хамгаалагчид, хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийж, тулгамдаж буй асуудлыг нэгтгэх

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

1. Шүд, амны хөндий, элэг, бөөр, дотор, эмэгтэйчүүдийн болон халдварт бус өвчний илрүүлэг үзлэг, оношилгоонд нас насын бүлгийн 700-аас доошгүй иргэдийг хамруулсан байна.

2. Хүн амын эрүүл мэндийн эрсдэл, насын онцлогт тохирсон сургалт, сурталчилгаанд 500-аас доошгүй иргэдийн хамруулсан байна.

3. Эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан байна.

4. Сумандаа хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөлийг судалж, сумын удирдлагатай хамтран сум орон нутгаас хамааралтай шийдэж болох асуудлыг шийдвэрлэсэн байна.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон асран хамгаалагчид, хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийж, тулгамдаж буй асуудлыг нэгтгэн бодлого төлөвлөлттэй уялдуулан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2025. оны

05. дугаар сарын 16-ны/ний өдрийн

А/530 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“ЭРҮҮЛ БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах албан тушаалтан
1	2	3
11:00-11:10	Хөтлөгч нээлтийн уг хэлнэ	Хөтлөгч Н.Аззаяа
11:10-11:20	Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир нээлтийг уг хэлнэ.	Хөтлөгч зарлана
11:20-11:30	Үг.Гэрэлчулун ая.А.Мөнх-Амьдрал “Булган нутгаа дуулъя”	Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын дуучин Н.Аззаяа
11:30-11:40	“Эрүүл Булган” хөтөлбөрийн танилцуулга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан ахлах мэргжилтэн М.Солонго
11:40-11:50	Үг.Х.Соёмбо ая. Цэвээнравдан “Булган хангай”	СТА Б.Гантэмэр, СТА. П.Золзаяа, Н.Аззаяа, СТА. Н.Мөнгөнтуяа

Аймгийн Засаг даргын 20-р оны

05. дугаар сарын 16.-ны/ний өдрийн

A/310 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦОГЦООР
ХҮРГЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ**

Д/Д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	
1	Шатахуун АИ-92 (4 машин тус бүр 560 км)	Литр	403,2	2520	1,016,064
2	Шатахуун дизель түлш (1 машин тус бүр 560 км)	Литр	100,8	3420	344,739
3	Зорилтот өрхөд олгох хүнсний багц	Ширхэг	40	25,000	1,000,000
4	Баннер	M ²	8	13,250	106,000
5	Эмч, эмнэлгийн мэргэжилтний томилолт	Хүн. Өдөр 9 хүн*4 өдөр	36	30000	1,080,000
	Нийт				3,546,803